



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/122

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1-ийн "б", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, 58 дугаар зүйлийн 58.2.20, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын "Аймгийн 2021 оны төсөв батлах тухай" 2020 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Зөгийн үүр" арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай хийх уулзалтыг 2021 оны 03 дугаар сарын 13,14-ний өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Уулзалтын арга хэмжээнд шаардагдах 2910000 /хоёр сая есөн зуун арван мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-г, уулзалтыг цаг хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Ж.Ганбаатар/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010340

Аймгийн Засаг даргын 2021 оны
...03... дугаар сарын 05 өдрийн ...А/122
дугаар захирамжийн хавсралт

“Зөгийн үүр” арга хэмжээний хүрээнд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл
эзэмшигч нартай хийх уулзалтыг зохион байгуулах төсөв

д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Цайны завсарлагааны зардал	140 хүн	10.000	1400.000
2	Хоол	22 хүн	55.000	1210.000
3	Бэлэг дурсгал			300.000
	Нийт			2910.000